МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 15 өдөр Дугаар А/599 Алтай хот

Хяналтын тооллого зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалт, 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2021 оны тооллогын ажилд хяналт тавьж ажиллах чиглэл, бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналтын тооллогын томилолт, шатахууны зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг мал тооллогын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Сумдын мал тооллогын комиссын ажилтай танилцан, гарсан зөрчил дутагдлыг тухайн орон нутгийн холбогдох ажилтнуудтай хамтран шийдвэрлэн үнэлэлт дүгнэлт өгч гарсан дүгнэлтийг аймгийн мал тооллогын комисст танилцуулахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ө.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201002082

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 15-ны өдрийн А/599 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА, ХУДГИЙН 2021 ОНЫ ТООЛЛОГО ХЯНАЛТЫН АЖЛААР ЯВАХ ЧИГЛЭЛ БҮРЭЛДЭХҮҮН

№	Явахчиглэл	Ахлагч	Гишүүд
1	Бигэр, Цогт, Эрдэнэ Цогт сумын Баянтоорой тосгон	ХХААГ-ын дарга Т.Сүхбаатар	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Батзориг ХХААГ-ын мэргэжилтэн Э.Пүрэвдорж
2	Дэлгэр, Есөнбулаг, Цээл, Алтай, Бугат, Дарив, Тонхил,	Статистикийн хэлтсийн дарга Д.Тунгалаг	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Цэрэнлхам, Б.Тогтохбаяр, Б.Төмөр-Очир ХХААГ-ын мэргэжилтэн Б.Сарантуяа

__oOo__

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 15-ны өдрийн А/599 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Явах чиглэл	Явах байгуулагын машин	Явахкм	Зарцуулах шатахуун	Шатахууны үнэ /төгрөгөөр/	Томилолтын Нийт хоног	Томилолт гишүүд	Жолооч Томилолтын хоног	Томилолтдун	Дүн
Бигэр, Цогт, Эрдэнэ, Цогт сумын Баянтоорой тосгон	ХХААГ	1340	268 л	696800	16	12	4	424000	1120800
Дэлгэр, Есөнбулаг, Цээл, Алтай, Бугат, Дарив, Тонхил,	Статистик	2085	417 л	1084200	30	24	6	795000	1879300
Нийт дүн			685	1781000	40	33	10	1219000	30000000

__oOo__